

УДИРТГАЛ ҮГ

Монгол Улсын Их Сургуулийн Монгол Судлалын Төв (МСТ) 2000 онд байгуулагдсан. “Монгол судлалын төвийн үйл ажиллагааг нийгэм, эдийн засаг, хэл, соёл, түүхийн чиглэлээр олон улсын монгол судлалын төв болгоно, монгол судлал бол МУИС-ийн судалгааны тэргүүлэх чиглэл мөн” гэж МУИС-ийг 2011-2020 хүртэл хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөнд зааж энэ чиглэлээр авах арга хэмжээний хүрээнд 2011 оны 8 дугаар сарын 1 ээс тус төвийг Монгол Судлалын Хүрээлэн (МСХ) болгон өөрчлөх өргөтгөх шийдвэр гарлаа. МУИС-ийн захирал МСХүрээлэнгийн Ерөнхийлөгчөөр хавсран ажиллаж байна. МСХүрээлэн нь гүйцэтгэх захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, эрдэм шинжилгээний ажилтан гэсэн бүтэцтэй байна. Хүрээлэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх зорилгоор бүтэцдээ төв болон эрдэм шинжилгээ, судалгааны багтай байж болно гэж журамд заасан.

Өнгөрсөн 5 сарын хугацаанд бид МСХ-гийн журмыг шинэчлэн боловсруулж батласны зэрэгцээ, тус хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн гадаад болон дотоод гишүүдийг томилон Монгол судлалыг хөгжүүлэх талаар санал солилцох хэлэлцүүлэгийг хэд хэдэн удаа зохион байгууллаа. Хэлэлцүүлэгийн явцад Монгол судлалын тэр дундаа МУИС-д монгол судлалыг хэрхэн хөгжүүлэх талаар олон санаа дэвшигдэн гарч үүний үр дүнд тус хүрээлэнгээс монгол судлалын чиглэлээр баримтлах стратеги, үзэл баримтлалын баримт бичгийг боловсруулж эхлээд байна.

Хүрээлэнгийн удирдлага Монгол Улсын БСШЯамнаас боловсруулж байгаа Монгол судлалыг хөгжүүлэх Засгийн газрын мөрийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, монгол судлалыг хөгжүүлэх талаар төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулах санал дэвшүүлж байна.

Бид түрүү түрүүчийн эрдэмтэн судлаачдын нэгэн адил монголын түүхэн сурвалж бичиг, уламжлалт соёл, боловсрол, мэдлэг ухаан, монгол үсэг бичиг, монгол хэлний түүхэн судлал, цааз хууль, эрт эдүгээгийн эдийн засаг, уламжлалт анагаах ухааны зэрэг монгол судлалын бүхий л чиглэлийн судалгааг хөхүүлэн дэмжиж, түүнийг хөгжүүлэхэд туслах зорилт тавьж байгаа. Манай хүрээлэн эрдэм шинжилгээний бүс нутгийн болон дотоодын, олон улсын хурал, симпозиум, семинарыг дангаараа болон хамтран зохион байгуулна. Бид 2011 оны 8 дугаар сарын 9-10 нд АНУ-ын монгол судлаач, Харвардын Их Сургуулийн профессор Францис Вүүдмэн Кливизийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлыг амжилттай зохион байгууллаа. Мөн хүрээлэнгийн захирал, эрдэм шинжилгээний ажилтан нар АНУ, Австрали, ХБНГУ, Япон, БНХАУ зэрэг оронд болсон эрдэм шинжилгээний хурлуудад илтгэл хэлэлцүүлээ.

Бид сүүлийн 10 жилийн хугацаанд эрдэм шинжилгээний “Acta Mongolica” сэтгүүлийн жил тутмын 10 дугаарыг хэвлүүллээ. Энэхүү шинэ дугаарыг мөн АНУ-ын монголч эрдэмтэн Ф.В.Кливизийн мэндэлсний 100 жилийн ойд зориулан хэвлүүлж байна. Энэ удаагийн дугаарт удиртгал үг бичиж, танилцуулга ирүүлсэн АНУ-ын Харвардын Их Сургуулийн Профессор Марк Эллиотод талархаж байгаагаа сэтгүүлийн зөвлөлийн нэрийн өмнөөс энэ дашрамд илэрхийлье.

Монгол судлалын судалгааны чиглэл өргөжиж, залуу судлаачдын тоо нэмэгдэж тэр хэрээр бүтээлээ хэвлүүлэх судлаачдын эрэлт хэрэгцээ шаардлага их байгаа учир “Mongolia: Area and

Culture Studies” нэрт англи хэлээр гарах шинэ сэтгүүлийг мөн танилцуулж эхний дугаарыг хэвлүүлэхэд бэлэн болоод байна.

Монголч эрдэмтдийн шинэ тугдам туурвисан бүтээлийг нийтлэх BIBLIOTHECA MONGOLICA, MONUMENTA MONGOLICA цувралуудыг үргэлжлүүлэн хэвлэхээр бэлтгэж байна. Энэ цувралын хүрээнд нэн ялангуяа шинэ залуу эрдэмтдийн шинэхэн бүтээлийн цуврал болох “Монгол хэлшинжлэлийн чуулган”, “Монгол соёлын чуулган”, “Монголын түүх судлалын чуулган”, “Эх бичиг судлалын чуулган” цувралуудыг ирэх оны хагас жилээс эхлэн хэвлэж гаргаж байхаар бэлтгэж санал авч байна.

МСХүрээлэнгийн өөр нэг гол ажил бол эрдэм шинжилгээний их семинар байх болно, үүнийг үргэлжлүүлэн хийнэ. Эрдэм шинжилгээний хүрээлэн болсноос хойшхи анхны семинарыг ШУА-ын Археологийн Хүрээлэнгийн Секторын эрхлэгч д-р профессор Ц.Төрбат “Археологийн шинжлэх ухааны монгол судлалд эзлэх байр суурь, өнөөгийн чиг хандлага” хэмээх сэдвээр хийлээ.

Гадаадын монгол судлалын төвүүдэд болж байгаа эрдэм шинжилгээний хурлуудад монголч эрдэмтдийг оролцуулах, тэднийг дэмжих, туслах, зохион байгуулах ажлыг хийнэ. Үүнд энэ 2012 онд АНУ, Канад, БНСУ, Япон зэрэг улсад болох олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад МУИС-ийн монголч эрдэмтэд ялангуяа залуу эрдэмтдийг оролцуулахыг дэмжинэ.

Хүрээлэн болж өргөжин нэр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан төвийн лого бэлгэдэлийг өөрчилж шинээр хийж танилцуулж байна.

МУИС-ийн болон Монголын монгол судлалыг дэлхий нийтэд танилцуулах, монгол судлалын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, бэхжүүлэх, эхлүүлэх зорилгоор өнгөрсөн 5 сарын хугацаанд АНУ-ын Харвард, Индиана, Висконсин, ХБНГУ-ын Бонн, Хумбольдт, Геттингэн, Австрийн ШУА, Францын Сорбоны Их сургууль, ИНАЛКО, БНУнгар Улсын Өтвош Лорандын Их Сургууль, Японы Токиогийн Гадаад Судлалын Их Сургууль, БНСУ-ын Ханкоок Гадаад Судлалын Их Сургууль, БНХАУ-ын Өвөр Монголын багшийн Их сургуулиудад зочилж, хамтын ажиллагааны талаар албаны хүмүүстэй хэлэлцээ хийж Монгол дахь монголын судлалын талаар лекц уншиж илтгэл тавьж, зарим эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, сургуулиудтай хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Хүрээлэнгийн өдөр тутмын ажлыг мэдээлэх зорилгоор мэдээллийн хэрэгсэл тэр дундаа дэлхий даяаныг хамарсан олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох вэбсайт, фэйсбүүк, твиттэрт хүрээлэнгийн албан ёсны хаяг нээгдсэнийг энэ дашрамд мэдээлэхэд таатай байна. Үүгээр манай төвөөс зохион байгуулах болон үйл ажиллагааны мэдээлэл дэлхий дахинаа өдөр тутам тараж мэдээлэл солилцож байх болно.

Та бүхнийг манай ажлыг дэмжин, зүйл бүрээр хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Монгол Судлалын Хүрээлэнгийн гүйцэтгэх захирал,
Хэлшинжлэлийн ухааны доктор, профессор
Жанцангийн БАТ-ИРЭЭДҮЙ
2011 оны 12 дугаар сарын 31